

Publish 
What You Pay

 ӨЛСӨН
ВСНАА
ИЙТЭЛ
иргэний нийгмийн эвсэл

ТАН ЭВСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН СЕМИНАРЫН ТАЙЛАН



2014 оны 05 сарын 15-16

Улаанбаатар хот

ГАРЧИГ

СЕМИНАРЫН ЗОРИЛГО

СЕМИНАРЫН ХӨТӨЛБӨР

РҮҮР БАРИМТ БИЧИГ ӨӨРЛӨЛТИЙН ГИНЖ

ТАН ЭВСЛИЙН ӨМНӨ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

ТАН ЭВСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ

ТАН ЭВСЛИЙН НӨӨЦИЙН ҮНЭЛГЭЭ

ТАН ЭВСЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

ТАН ЭВСЛИЙН 20014-2016 ОНЫ СТРАТЕГИЙН ТӨСӨЛ

ОРОЛЦОГЧДЫН НЭРС

ТОВЧИЛСОН ҮГ

АХБ – Азийн Хөгжлийн банк

АТГ- Авилгатай тэмцэх газар

ДБ – Дэлхийн банк

ЕСБХБ – Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк

ИНБ – Иргэний нийгмийн байгууллага

НБДНГ – Нарийн бичгийн дарга нарын газар

НҮБХХ – Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр

ННФ- Нээлттэй Нийгэм Форум

ОУ – Олон улс

ОУИТБС – Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын санаачлага

ОАХ- Орлогын Ажиглагч Хүрээлэн

PWYP - “Publish What You Pay” ОУ-ын Иргэний нийгмийн байгууллага

ТАН – Төлсөн Авснаа Нийтэл

ТН – Төлснөө Нийтэл Олон улсын сүлжээ баийгууллага

ТББ – Төрийн Бус Байгууллага

ТАЛАРХАЛ

Төлсөн Авснаа Нийтэл иргэний нийгмийн эвслийн 2014-2016 оны стратеги боловсруулах төлөвлөлтийн семинарыг удирдсан PWYP НБДНГ-ын Евра Азийн бүсийн зохицуулагч Ольяана Валигура болон тус семинарт идэвхи санаачлагатай оролцсон эвслийн гишүүддээ зохицуулах зөвлөлийн гишүүдийн өмнөөс талархал илэрхийлье.

ТАН эвсэл

www.tanevsel.wordpress.com

pwypmgl@yahoo.com

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:

“Төлсөн авснаа нийтэл” эвсэл ОУ-ын “Төлснөө нийтэл” сүлжээний Евра Азийн бүсийн зохицуулагч Ольяана Валигурагийн удирдлага, арга зүйн дэмжлэгээр эвслийн 2014-2017 оны стратеги, 2014-2015 оны үйл ажиллагааны төлөвлөлтийн семинарыг Улаанбаатар хотноо 2014 оны 05 сарын 15-16 өдрүүдэд Пума империал зочид буудлын хурлын танхимд зохион байгууллаа.

Стратегийн бодлого боловсруулах семинарт эвслийн 29 байгууллагын төлөөлөл 20 хүн оролцлоо.

1. СЕМИНАРЫН ЗОРИЛГО:

- I. Монголын “Төлсөн авснаа нийтэл” эвслийн гишүүдийн оролцоонд тулгуурлаж Олон улсын РWYР-ийн 20/20 алсын хараа, “Өөрчлөлтийн гинж” баримт бичиг болон ОУИТБС-ийн шинэ стандартын дагуу ТАН эвслийн стратегийг тодорхойлох;
- II. Олон улсын иргэний нийгмийн Publish What You Pay хөдөлгөөний зарчмуудыг танилцуулж, олон улсын нарийн бичгийн дарга нарын газартай хамтран ажиллах боломжуудийг тогтоох;
- III. Эвслийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох ба удирдлага ба тайлагналыг бэхжүүлэх;

Хүлээгдэж буй үр дүн:

- a. Өөрийн орны нөхцөл байдал, 20/20 алсын хараа, ОУИТБС-ийн шинэ стандартад нийцсэн Эвслийн үндэсний стратегийн анхны хувилбар
- b. Олон улсын РWYР хөдөлгөөн, түүний удирдлага, стандартууд, хамтын ажиллагааны талаар мэдлэгээ гүнзгийрүүлэх
- c. Эвслийн удирдлагын механизм ба тайлагналыг бэхжүүлэх тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох.

2. СЕМИНАРЫН ХӨТӨЛБӨР:

Монголын РWYР эвсэлд дүн шинжилгээ хийх , Стратеги боловсруулах

| Хугацаа | Сэдвүүд | Зорилго / Хэлбэр | Модератор |
|------------------------------------------|-------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|
| 2014 оны 05 сарын 15. Пүрэв гараг | | | |
| 09:30 – 10:00 Бүртгэл | | | |
| 10:00 – 10:30 | <i>Нээлт, Танилцуулга</i> | Семинарын хөтөлбөр, зорилго, арга хэлбэрийг танилцуулах. Эвслийн үйл ажиллагааны талаар танилцуулга хийх. Оролцогчдыг танилцуулах. Семинараас юу хүлээж байгаа тухай . Семинарын дотоод журам | Н.Баярсайхан |

| | | | |
|--------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------|
| 10:30 – 11:10 | <i>РВҮР-ийн 20/20 алсын хараа ба Өөрчлөлтийн гинжийг танилцуулах</i> | 20/20 алсын хараа, стратегийн цар хүрээ, зааг ялгаа, шалгуур үзүүлэлтүүдийн тухай презентаци. Асуулт хариулт, ярилцах | Ояна Валигура |
| 11:10 – 11:30 | <i>Эвслийн ололт амжилт ба сорилтууд</i> | Бүлгийн ажил. Хоёр хоёрроороо бүлэг болж эвслийн сорилт а тулгамдсан асуудлуудын талаар шүүрхай хэлэлцээд, цаасан дээр бичээд хананд нааж цаашид хэлэлцэхэд бэлэн болгох | Бүгд |
| – Цайны завсарлага – | | | |
| 11:30 – 11.45 | | | |
| 11:45 – 13:00 | <i>РВҮР-ийн Өөрчлөлтийн гинж. Монголд ямар боломж байна вэ?</i> | <i>Бүлгийн ажил:</i> <i>Одоогийн нөхцөл байдал ба Өөрчлөлтийн гинж Эвсэлд хэрхэн хамаарах талаар зураглах</i> <i>Оролцогчид бүлгээр ажиллаж Өөрчлөлтийн гинжээр орон нутгийн болон үндэсний нөхцөл байдал, мэдлэг, мэдээллийн ямар хомсдол ба боломжууд байгааг хэлэлцэх</i> | Ояна Валигура Бүгд |
| 13.00 –14.00 Үдийн хоол | | | |
| 14:00 – 15:45 | <i>Үндэсний стратегийг тодорхойлох</i> | Хүлээж байгаа үр дүнгээс хамаарч үндэсний стратегийн боловсруулах зорилго, чиглэлийг тодорхойлно. Стратеги боловсруулах бүлгийн ажил: нөөц, чадвар, дадал, хэрэгцээ, мэдээлэл ба өгөгдлийн хомсдол, шинэ түншүүд ба холбоотнуудыг олж тогтоох | Бүгд |
| – Цайны завсарлага – | | | |
| 16:00 – 16:30 | <i>Юунд уриалж буйгаа өөрөө хэрэгжүүл: Эвслийн үйл ажиллагааны үр ашигтай байдлыг тодорхойлох. Нэгдүгээр хэсэг.</i> | Эвслийн удирдлага ба тайлагналын механизмыг хэлэлцэх | Н.Баярсайхан Д.Цэрэнжав Ояна Валигура. |
| 16:30 – 17:30 | <i>Юунд уриалж буйгаа өөрөө хэрэгжүүл: Эвслийн үйл ажиллагааны үр ашигтай байдлыг тодорхойлох. Хоёудагаар хэсэг.</i> | Үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх дадлага ажил | Бүгд |

| | | | |
|------------------------------------|----------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|
| 17:30 – 18:00 | <i>Дүгнэлт ба хаалт</i> | Эвслийн үйл ажиллагааны дүн шинжилгээний дүн Үндэсний тэргүүлэх чиглэл ба зорилтуудыг үнэлэх | Ояна Валигура. Н.Баярсайхан |
| 2014 оны 05 сарын 16 Баасан | | | |
| 09,00- 13,00 | <i>Семинарын дүгнэлт хийх, Тан эвслийн үйл ажиллагааг үнэлэх</i> | Сонирхлоороо оролцж байнаа гишүүдийн хүрээнд ажиллана. Гэхдээ баграар ажиллана 11,30- д цайны завсарлага. 13,00 үдийн хоол | Бүгд |
| 14,00- 18,00 | <i>ТАН эвслийн стратегийн баримт бичгийн төсөл боловсруулах.</i> | ТАН эвслийн байранд баримт бичиг боловсруулах жижиг ажлын хэсэг | Ояна Валигура. Н.Баярсайхан |
| 18,00- 20,00 | <i>РWYР- ТАН эвслийн хматын ажиллагааны талаар ярилцах</i> | Бүсийн зохицуулагч, ТАН зохицуулагч орчуулагчийн хамтарсан уулзалт | Ояна Валигура. Н.Баярсайхан |

3. РWYР БАРИМТ БИЧИГ: 20/20 АЛСЫН ХАРАА, ӨӨРЧЛӨЛТИЙН ГИНЖ

Энэхүү хөгжлийн стратегийн баримт бичгийг ОУ-ын РWYР байгууллага гишүүн ТН байгууллагуудын оролцоотой 2010 онд 2020 он хүртэлх алсын хараа, хөгжлийн алхмуудаа харж тодорхойлсон ба “Өөрчлөлтийн гинж” гэж нэрлэх болсон байна. Улс бүрийн ТН эвслүүд нь “Өөрчлөлтийн гинж” – ийн 12 алхамуудаас сонголт хийж үйл ажиллагааны хүрээ, үйл ажиллагааны чиглэлээ тогтоож алхамуудыг зэрэгцүүлж эсвэл үе шаттайгаар төлөвлөж ажиллах болсон байна.

“Өөрчлөлтийн гинж” баримт бичиг нь 4 үндсэн хэсэгт хуваагддаг, хэсэг бүр нь 12 алхамуудтай. Энэ нь:

I. Яагаад төлдөг ба хэрхэн олборлодгоо нийтэл хэсэг 4 алхамтай

- 1) Манай байгалийн нөөц ямар вэ?
- 2) Байгалийн нөөцийн тухай хууль эрх зүйн орчин ямар байна вэ?
- 3) Олборлох уу, эс олборлох уу?
- 4) Гэрээ хэлэлцээрийн хамгийн сайн хувилбарыг яаж олох вэ?

II. Хичнээнийг төлдөгөө нийтэл хэсэг 1 алхамтай

- 5) Төслийн мониторинг яаж хийх вэ?

III. Хичнээн орлого олж хэрхэн зарцуулдгаа нийтэл хэсэг 5 алхамтай

- 6) Компаниуд ямар төлбөр хийдэг вэ?
- 7) Мөнгө төрийн санд орж байна уу?
- 8) Эдгээр мөнгө чухам юунд зарцуулагдах ёстой вэ?
- 9) Мөнгө зориулалтаараа очиж байна уу?
- 10) Ингэж хичээх шаардлагатай юу?

IV. Юу тунхагласнаа хэрэгжүүл хэсэг 2 алхамтай

- 11) Үнэлгээг үргэлж хийж бай.
- 12) Бужигнаж дууссаны дараа тус тус байхаар төлөвлөжээ.

“ӨӨРЧЛӨЛТИЙН ГИНЖ”

Яагаад төлдөг ба хэрхэн олборлодгоо нийтэл хэсэг

1. Манай байгалийн нөөц ямар вэ?

Улс орныхоо байгалийн нөөцийн тоо хэмжээ, чанар ба байршлын талаар бүрэн мэдээлэл авахгүйгээр иргэд байгалийн баялгаа олборлох уу үгүй юу, хэрвээ олборловол ямар нөхцлөөр, түүнчлэн үр ашгийг шударгаар хүртэж чадах уу гэсэн шийдвэрийг гаргаж чадахгүй.

2. Байгалийн нөөцийн тухай хууль эрх зүйн орчин ямар байна вэ?

Иргэний нийгэм нь зөвлөлдөх үйл явц, танин мэдүүлэх сурталчилгаа зэрэг бүх л боломжийг ашиглан Газрын тосны тухай хууль, Уул уурхайн олборлох салбарын хэм хэмжээ зэрэг эрх зүйн баримт бичигт нөлөөлөхийг хичээж, бүр эхнээс нь байгалийн нөөцийг ашиглах үйл явцын ил тод байдал ба хариуцлагын зарчмыг тусгахыг шаардах ёстой.

3. Олборлох уу, эс олборлох уу?

Байгалийн нөөцийг ашиглах төслүүдийн үр дагавар, үр ашиг ба үр дүнгийн талаархи мэдээллээр хүн амыг хангахад иргэний нийгмийн байгууллагууд туслах боломжтой. Эдгээр төслийн нөлөөллийн үнэлгээг ил тод, хараат бусаар явуулж, дүн нь орон нутгийн иргэдэд хүртээмжтэй байх ёстой. Бас төслүүдээс гарч болзошгүй аливаа нөхөн төлбөрийг төлөвлөх ёстой.

4. Гэрээ хэлэлцээрийн хамгийн сайн хувилбарыг яаж олох вэ?

Гэрээ хэлэлцээр хэр үр ашигтай болсныг илэрхийлэх тусгай зөвшөөрлийг ил тодоор олгож, гэрээг мөн тэгж байгуулах ёстой. Нийт хүн амын ашиг сонирхолд нийцсэн гэрээг байгуулахын тулд сонгон шалгаруулалтын үйл явц өрсөлдөөнтэй, нийтэд нээлттэй байж, байгуулсан хэлэлцээрүүдийг нийтлэх ёстой.

Яагаад төлдөг ба хэрхэн олборлодгоо нийтэл

5. Төслийн мониторинг яаж хийх вэ?

Хяналт тавихад иргэний нийгэм маш чухал үүрэгтэй бөгөөд “хоточ нохой” мэт байдаг. Төслийг төр засаг, олборлох компаниуд, бас хараат бус механизм, иргэний нийгэм хянаж нөхцөл байдал өөрчлөгдөх, гэрээний заалтыг зөрчих зэрэг ямар ч асуудлыг хүний эрхийн зөрчлийн үүднээс шүүхээр шийдүүлэх, нөхөн төлбөр олгохыг шаардах болон бусад арга замаар залруулж байх ёстой.

Хэдийг төлснөө нийтэл

6. Төслийн мониторинг яаж хийх вэ?

Улс орон байгалийн баялгаасаа хичнээнийг олдог талаар иргэд нь мэддэг байх, мөн шаардлагатай тохиолдолд засаг төрөөсөө хариуцлага нэхэх нөхцлийг бүрдүүлэхийн тулд компаниуд хэдийг төлдөг тухайгаа нийтлэхийг бид шаардах ёстой. Ингэснээр компаниуд нягтлан бодох бүртгэлийг будлиантуулах замаар зарим төлбөрөөс зайлсхийхээс сэргийлэх юм.

Хэдийг олж хэрхэн зарцуулдгаа нийтэл

7. Мөнгө төрийн санд орж байна уу?

Мөнгөн хөрөнгийг замаас нь гувчуулахгүй, “алдагдах”-гүй байхын байгалийн нөөцөөс олсон орлого (төр засгийн аль түвшинд гэдгээс үл хамааран) нээлттэй байж, түүнийг тайлагнах ёстой. Иргэний нийгмийн зүгээс төсөл бүрээс орсон орлогыг хянаж компани ба төр засгийн зарласан тоо хоорондоо нийцэж байгаа эсэхийг нягтлах боломжтой байх хэрэгтэй.

8. Эдгээр мөнгө чухам юунд зарцуулагдах ёстой вэ?

Иргэний нийгэм төсвийн нээлттэй байдал ба төсвийн хөрөнгийг хуваарилах нэн тэргүүний чиглэлийг тодорхойлохыг Засгийн газраас шаардах ёстой.

9. Мөнгө зориулалтаараа очиж байна уу?

Ашиг орлогоо хуваарилагдсаны дараа иргэний нийгэм хөрөнгө мөнгө зориулалтаараа очсон эсэхийг хянаж, хэрвээ замдаа үрэгдсэн бол арга хэмжээ авахыг шаардах ёстой.

10. Ингэж хичээх шаардлагатай юу?

Ашиг орлогыг зөв зарцуулж, улс орны хөгжил, ард иргэдийн амьдралыг дээшлүүлэхэд зориулсан эсэхийг хөндлөнгийн этгээд үнэлж дүгнэх ёстой.

Олж мэдсэнээ нийтэл

11. Үнэлгээг үргэлж хийж бай

Талууд, түүний дотор иргэний нийгэм нь янз бүрийн бүтэц, зохион байгуулалтын зөв буруу, зохистой эсэхийг алсын хараатайгаар байнга үнэлж байх ёстой. Илт хуучирсан бүтэц ба гэрээ хэлэлцээрийн талаар санаа зовниж буйгаа нээлттэй илэрхийлснээрээ иргэний нийгэм чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм.

12. Бужигнаж дууссаны дараа?

Магадгүй, энэ нь алс хэтийн асуудал боловч тодорхой төслийг хэрхэн үр ашигтайгаар дуусгах, задалж тараах, түүний эргэн тойронд бүрэлдсэн эдийн засгийн бүтцийг орон нутгийн иргэдэд хохирол багатайгаар хэрхэн шийдвэрлэх талаар авч үзэх нь чухал юм.

4. ТАН ЭВСЛИЙН ӨМНӨ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Төлөвлөлтийн семинарт оролцогчид багаар хэлэлцээд дараах асуудлууд нь эвслийн үр дүнтэй үйл ажиллагаа явуулахад бэрхшээл болж байна гэж үзсэн болно. Үүнд:

А. Олборлох салбарын ил тод байдлыг хангахад:

- Уул уурхайн салбар дахь гэрээ хэлэлцээр хаалттай хийгддэг.
- Уул уурхайн компани жинхэнэ эзэн, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийг ил тод нээлттэй байлгах эрх зүйн орчин байдаггүй.
- Уул уурхайн лицензийн зөвшөөрөл олгоход уугуул иргэд, орон нутгийн захиргааны оролцоо байхгүй, нэр төдий хуульчлагдсан
- Хайгуулын лицензтэй компани хувьцаа босгох хуулийн заалт байхгүй байтал ОУ-ын хөрөнгийн бирж дээр хөрөнгө босгодог, үүнд монголын талаас ямар ч хяналт хийж чаддаггүй
- Уугуул иргэд компани хоёр хэтэрхий тасархай 2 тийшээ харсан байдал, нийгмийн үүл уурхайн талаарх сөрөг ойлголт өндөр байгаа байдал
- Худалдан авах гэрээ, бэлтгэн нийлүүлэх гэрээ, боловсруулалтын гэрээ зэрэг нь ил тод байдаггүй
- Уугуул иргэдэд урьдчилж мэдээлэл өгөх, түүний дараа шийдвэр гаргуулах гэсэн зарчмын хэрэгжилт уул уурхайн салбарт дутагдалтай байгаа. Хэрвээ эрх нь зөрчигдсөн тохиолдолд гомдол гаргах зарчмыг МУ-ын хуулиар хуульчлах асуудал
- ОУИТБ-ын тайлан өгөөгүй, худал мэдээлсэн, тайлагнасан ч гэсэн иргэдэд нээлттэй, хүртээмжтэй мэдээлж тайлагнах үүргээ хэрэгжүүлээгүй бол төр компани 2-т ямар хариуцлага хүлээлгэх хуулийн заалт байхгүй
- Өнгөрсөн хугацаанд 7 тайлан гарсан, зөрүү гарсаар байгаа, жил бүрийн тайланд яг ижил агуулгатай дүгнэлт зөвлөмж өгөгдөөд байдаг. Гэвч түүний үл мөрөөр Үндэсний зөвлөл ямар ч арга хэмжээ авдаггүй.
- Олборлох салбарын үйл ажиллагаа явагдаж байгаа сум нэгжид шууд орох орлого бага, шилжүүлгээр очихдоо бусад уурхайгүй сумдтай адил Төсвийн тухай хуулиар итгэлцүүрээр хувиарлагдаж очдог. Агаарын төлбөр Улаанбаатар хотын дансанд ордог гэх мэт байдал нь орон нутгийн иргэдийн санаачилга түүний тайланд оролцох сонирхох оролцоог хязгаарлаж байна



В. ТАН эвслийн хувьд:

- ТАН эвслийн хувьд санхүүгийн нөөц хязгаарлагдмал байдгаас төрөл бүрийн олон нийтэд хандсан кампанит ажлыг хүчтэй явуулж чадахгүй байна.
- ОУИТБС-д болон уул уурхайн асуудлаар шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар их ажиллах шаардлага байгаа ч нөөц байхгүй байна

- Засгийн газар олсноо юунд зарцуулж байгааг, УИХ хэрхэн хувиарлаж байгааг нь тодорхой ил тол болгох гэхээр улсын төсвийн тогооноос ялгаж харах боломжгүй гээд мэдээлэл өгдөггүй Үүнийг хянах арга, ур чадвар дутагддаг
- Тайланг ашиглахгүй байна. Эвслийн гишүүд ч тэр, олон нийт ч тэр, УИХ, ИТХ, засгийн газрын байгууллагууд бүх шатандаа тайланг ойлгож ашиглах, энгийн болгож боловсруулан нийтэд хүргэх талаар ур чадвар, мэдлэг дутагддаг
- Төрийн мэдээллийг цахим болгосон нь сайшаалтай хэдий ч хөдөө орон нутагт интернет ашиглах боломжгүй хүмүүс төрийн байгууллагаас мэдээлэл хүсэхээр манай сайтад байгаа тэндээс ав гэдэг болсон нь их учир дутагдалтай байна.
- МУ-д байгаа донорууд ОУИТБ-ын үйл ажиллагааг дэмжих сонирхол бага байна. Донорууд бидний ажлыг өөрсдөө хийсэн болж өөрсдөө хөтөлбөртөө төсвөө нэмүүлдэг, төсөл бичдэг байдал
- АМТХ-д саналаа өгөх кампанит ажил хийх шаардлагатай байгаа
- Орон нутгийн иргэдийг чадавхжуулах сургагч багш бэлтгэгдсэн. Сургалт сурталчилгаа хийх хөрөнгө босгох, санхүүгийн дэмжлэг туслалцаа хэрэгтэй байна.
- Орон нутагт шинэ стандартыг маш зөв, сайн сурталчлах гэсэн асуудлууд гарсан байна.

5. ТАН ЭВСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ:

ТАН эвслийн засаглал, түншлэл, удирдлага, зохион байгуулалт, ОУИТБС-д оролцож буй оролцоог үнэлэх, түвшин тогтоох үнэлгээг тусгай аргачлалаар хийлээ.

Энэхүү үнэлгээний зорилго:

1. Эвслийн давуу болон сул талуудыг тогтоож, тэргүүлэх ач холбогдол бүхий алхамд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлно
2. Эвслийн удирдлага-тайлагналын тогтолцоог бэхжүүлж буй явц.
3. Мэдээлэл солилцох, гишүүдэд, олон нийтэд мэдээлэл нээлттэй байх, эвсэл засаглалын наад захын нийтлэг стандартыг хэрэгжүүлж буй үйл явцыг үнэлэх юм.

Үнэлгээ үндсэн 2 хэсэгтэй:

1-р хэсэг: Эвслийн засаглалын ил тод байдал:

2-р хэсэг. Үр ашигтай ажиллаж чаддаг эвсэл байгуулах үндсэн шалгууруудаар эвслийг үнэлэх:

| Түвшин | Үнэлгээний тайлбар |
|----------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 5-р түвшин: | Өөрчлөлт хийх тэргүүлэх чиглэлүүдийг эрэмбэлэх |
| 4-р түвшин: | Эвсэл одоогийн түвшинд үйл ажиллагаа явуулах нь зүйтэй, гэхдээ цаашдаа өөрчлөлт хийх талаар бодож төлөвлөвөл зүгээрсэн. |
| 3-р түвшин: | Эвслийн үйл ажиллагаа маш тодорхой болж цэгцэрсэн. Гэхдээ зарим талаар сайжруулах юм бий. |
| 2-р түвшин: | Эвсэл одоогийн түвшинд ажиллах нь зүйтэй. Маш тодорхой үйл ажиллагаатай, цэгцэрсэн байгуулага гэдгээ харуулж байна. |
| Хамгийн дээд түвшин: | Эвсэл одоогийн түвшинд ажиллах нь зүйтэй. (Гэхдээ газар газрын эвслүүд ийм байж бараг чадахгүй, тэр тусмаа бүх шаардлагуудыг зэрэг хангаж чаддаггүй) |

ҮНЭЛГЭЭ 1. ЭВСЛИЙН ЗАСАГЛАЛЫН ИЛ ТОД БАЙДАЛ:

| | | |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------|------|
| Асуулт бүрт ТИЙМ, ҮГҮЙ тэмдэг тавина. Бүлгээр ажиллаж дүгнэнэ. | Тийм | Үгүй |
| Эвслийн бүх гишүүдийн э-шуудангийн хаяг жагсаалт байдаг уу? | × | |
| Эвслийн гишүүд нь бусад гишүүдтэй хялбар холбогдох боломжтой юу? | × | |
| Та эвслийн засаглал болон удирдлагын бүтцэд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийн баримтжуулалтыг гишүүдэд шуурхай мэдэгддэг үү? | × | |
| Эвслийн санхүүгийн тайлан гишүүдэд нээлттэй юу? Интернетэд байдаг уу? | × | |
| Эвслийн гишүүн байгууллагууд албан ёсоор бүртгэгдсэн байгууллагууд уу? | × | |
| Танай эвслийн талаар олон улсын нарийн бичгийн дарга нарын газар шууд мэдээлэх боломжтой эсэх? | × | |
| <ul style="list-style-type: none"> • Уулзалтын тэмдэглэл нээлттэй юу? • Хурлын шийдвэр тухай бүр нээлттэй байж гишүүдэд хүрдэг үү? • Гишүүдийн бүрэлдхүүнд өөрчлөлт орсон тухай бүр жагсаалт шинэчлэгддэг үү? • Гишүүн элсүүлэхдээ гишүүнчлэлийн шалгуур тавьдаг уу? • Зохицуулагчын ажлын байрны тодорхойлолт , эсвэл жагсаалт байдаг уу? • Зохицуулах зөвлөлийн тодорхойлолт байдаг уу ? • Стратеги төлөвлөгөө байдаг үү? | <ul style="list-style-type: none"> × × × × × | × |
| Эвслийн тэргүүлэх чиглэл нь “Өөрчлөлтийн гинж”-ийн аль алхам бэ? | | |
| a. Яагаад төлдөг ба хэрхэн олборлодгоо нийтэл | × | |
| b. Хичнээнийг төлдөгөө нийтэл | × | |
| c. Хичнээн орлого олж хэрхэн зарцуулдгаа нийтэл | × | |
| d. Юу тунхагласнаа хэрэгжүүл | | × |

ҮНЭЛГЭЭ 2. ҮР АШИГТАЙ АЖИЛЛАЖ БАЙГАА ЭСЭХ:

А. Удирдлага ба зохицуулалт

Удирдлага ба зохицуулах байгууллага нь эвслийн алсын харааг тодорхойлох ажлыг зохион байгуулдаг ба гишүүддээ чөлөөтэй ажиллах боломж олгож энэхүү алсын хараанд хүрэхийн тулд хамтран ажиллах хүсэл эрмэлзлэлийг дэмждэг.

| Түвшин | A-i. Нэгдсэн стратеги ба зорилго | A-ii. Удирдлага ба удирдах хорооны тайлагнал |
|--------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1.Өөрчлөлт хийх тэргүүлэх чиглэлүүдийг эрэмбэлэх | Эвслийн гишүүд нийтлэг зорилгоо тодорхойлсон боловч түүнд хүрэх ямар арга зам хамгийн чухал болох талаар зөвшилцөж чадаагүй. Эвсэл нь гэдэг нь янз бүрийн арга хэмжээ зохион байгуулахаас өөр ямар практик ач холбогдолтой юм бэ гэдэг нь бүрэн тодорхой биш, улмаар хамтран ажиллах эрмэлзэл сүл | Албан ёсны удирдах байгууллага байхгүй, нэг гишүүн бусдыгаа манлайлж удирдагчийн үүргийг гүйцэтгэдэг, харин бусад нь шийдвэр гаргахад бага сага оролцдог ба тэдэнд мэдээлэл өгдөггүй. Гишүүд бүгдээрээ уулзалдах нь маш ховор. |

| | | |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>2.Эвсэл одоогийн түвшинд үйл ажиллагаа явуулах нь зүйтэй, гэхдээ цаашдаа өөрчлөлт хийх талаар бодож төлөвлөх нь зүйтэй</p> | <p>Гишүүд бие биендээ төдийлөн итгэдэггүй учраас тэднийг стратегийн шийдвэр гаргахад ухуулах шаардлага тулгардаг. Кампанит ажил хэрхэн явуулах стратеги ба эвслийг удирдан зохион байгуулах талаар зөвшилцөлд хүрэхэд ихээхэн хүчин чармайлт шаардагддаг.</p> | <p>Зарим гишүүд бусдаасаа идэвхтэй. Тэд сайн дураараа уулзалдаж, эвсэлд юу шаардлагатайг хэлэлцдэг цөмийг бүрдүүлдэг ба эвслийн үйл ажиллагааны талаар янз бүрийн санал хэлдэг. Өөрөөр хэлбэл бусдаасаа тусгаарлагдсан хэдхэн хүн шийдвэр гаргадаг.</p> |
| <p>3.Эвслийн үйл ажиллагаа маш тодорхой болж цэгцэрсэн. Гэхдээ зарим талаар сайжруулах юм бий.</p> | <p>Эвслийн зөв стратегийн талаар гишүүд янз бүрийн байр суурь илэрхийлдэг ч үүнээс хамаарахгүйгээр өөр хоорондоо үр ашигтай хамтран ажиллаж чаддаг. Тэд Өөрчлөлтийн гинжний зорилтуудыг хэрэгжүүлэхэд хүчин чармайлтаа төвлөрүүлж ёстой гэдэг дээр санал нийлдэг.</p> | <p>Албан ёсны удирдах хороо (буюу хүлээн зөвшөөрөгдсөн удирдах байгууллага) байдаг боловч, байнга хуралддаггүй. Энэхүү удирдлага нь эвслийн бүх гишүүдийн төлөө ажиллаж байгааг гишүүд ерөнхийдөө ойлгодог. Гэхдээ удирдах хорооны эрх мэдэл хязгаарлагдмал бөгөөд гол төлөв зөвлөх үүргийг гүйцэтгэдэг.</p> |
| <p>4.Эвсэл одоогийн түвшинд ажиллах нь зүйтэй. Маш тодорхой үйл ажиллагаатай, цэгцэрсэн байгууллага гэдгээ харуулж байна.</p> | <p>Гишүүд нягтарч, нэг зорилго тавьж түүндээ хүрэх стратегиа хамтран боловсруулдаг хамт олон болж чадсан. Гишүүд хамтрын ажиллагаандаа сэтгэл хангалуун байдаг ба эвслийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг.</p> | <p>Удирдах хороо нь албан ёсоор тодорхойлсон үүрэг хүлээдэг ба ажлаа тайлагнах зарим тодорхой журам бий. Хороо нь байнга хуралдаж, эвслийн ажлын үр дүнг хэлэлцэхийн зэрэгцээ стратегийн талаар зөвлөмж шийдвэр гаргадаг. Тэдний шийдвэр бусад гишүүддээ нээлттэй байдаг. Зарчмын шийдвэрүүдээ байнга болдог хурлаараа бүх гишүүд санал хурааж гаргадаг.</p> |
| <p>5.Эвсэл одоогийн түвшинд ажиллах нь зүйтэй. (Гэхдээ газар газрын эвслүүд ийм байж бараг чадахгүй, тэр тусмаа бүх шаардлагуудыг зэрэг хангаж чаддаггүй)</p> | <p>Гишүүд улс орныхоо өөрчлөгдөж байгаа нөхцөл байдлыг анхаарч түүнийг дагуу алсын хараа, зорилтуудаа шинэчлэх талаар санал нэгтэй байдаг. Гишүүд Өөрчлөлтийн гинжний талаар ямар хэсэгт анхаарлаа төвлөрүүлэх талаар зөвшилцөлд хүрсэн. Тэд бие биендээ дээд зэргээр итгэж амжилт төдийгүй эрсдэл, хариуцлагаа хуваалцахад бэлэн байдаг.</p> | <p>Удирдах хорооны эрх хэмжээг байнга болдог хурлаар эвслийн гишүүд өөрсдөө тогтоодог. Бүх гишүүдээр нээлттэй сонгогддог учраас удирдах хороо нь гишүүддээ захирагддаг. Уирдах хороо нь эвслийн бүх гишүүдийн өмнөөс шийдвэр гаргах эрхтэй бөгөөд тэдний өмнө ажлаа байнга тайлагнадаг. Удирдах хороо нь зохицуулагчийг ажилд авдаг (бас халдаг)</p> |

| Түвшин | A-iii. Эвслийн үйл ажиллагааны зохицуулалт | A-iv. Нөөц боллоцоогоо дайчлах нь |
|-------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>1.Өөрчлөлт хийх тэргүүлэх чиглэлүүдийг эрэмбэлэх</p> | <p>Үйл ажиллагааны ихэнхийг (жишээлбэл, чадавхи бий болгох, мэдээлэл сурталчилгаа явуулах, хурал зохион байгуулах, мэдээлэл бэлтгэх, төсөл боловсруулах гэх мэт) нэг гишүүн гүйцэтгэдэг. Уг нь бусад гишүүд ч гэсэн оролцох сонирхолтой төдийгүй тийм боломжтой.</p> | <p>Санхүүжилт байхгүй нь эвслийн тулгамдсан асуудал бөгөөд тавьсан зорилгодоо хүрэхэд саад учруулдаг.</p> |
| <p>2.Эвсэл одоогийн түвшинд үйл ажиллагаа явуулах нь зүйтэй, гэхдээ</p> | <p>Гишүүдийнхээ бодол санааг ерөнхийд нь сонсож, эвслийн үйл ажиллагааны талаархи санал шүүмжийг хүлээн авах</p> | <p>Эвсэлд мөнгө юмуу цаг дутагддаг учраас төлөвлөснөө тэр болгон хэрэгжүүлж чаддаггүй. Санхүүжилттыг идэвхтэй эрж</p> |

| | | |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <i>цаашдаа өөрчлөлт хийх талаар бодож төлөвлөх нь зүйтэй</i> | замаар бусад гишүүдийг ойртуулж хамтран ажиллахыг хичээдэг хэдий ч ерөнхийдөө явцуу хүрээнд ажилладаг. | хайхад бага цаг зарцуулдаг тул эвслийн ажил нь тухайн үед боломж гарч ирэх эсэхээс хамаардаг. Эвслийн ажилд оролцохын тулд гаргадаг зардал чирэгдэл нь түүнээс хүртэх ашиг шимээс хэтэрдэг тул гишүүд хувь нэмрээ оруулахад сөргөөр нөлөөлдөг. |
| 3.Эвслийн үйл ажиллагаа маш тодорхой болж цэгцэрсэн. Гэхдээ зарим талаар сайжруулах юм бий. | Хүлээн зөвшөөрөгдсөн “зохицуулагч” юмуу өөр зохицуулах механизм (хувь хүн эсвэл дэд хороо) байдаг. Энэхүү “зохицуулагч” нь гишүүдийг аль болох олноор татан оролцуулахын тулд заримд тус тусын үүрэг даалгавар өгч ажилладаг. | Эвсэл нь төлөвлөгөөтэй боловч үр дүн муутай ажилладаг. Санхүүжилт эрж хайхад ихээхэн хүч чармайлт зарцуулдаг хэрнээ багахань олдог. Гишүүд эвслийн ажилд зохих цаг заваа зориулах ёстойгоо ухамсарладаг ч чухам юу хийхээ тэр болгон мэддэггүй. |
| <i>4.Эвсэл одоогийн түвшинд ажиллах нь зүйтэй. Маш тодорхой үйл ажиллагаатай, цэгцэрсэн байгуулага гэдгээ харуулж байна.</i> | “Зохицуулагч” үйл ажиллагаа явуулахдаа зарим гишүүдэд хандаж бусдынхаа цаг зав, сонирхол, мэргэжил болон одоогийн ажил төрлийг харгалзан хамтран ажиллахыг уриалж чиглүүлдэг. | Эвсэл нь төлөвлөснөө хэрэгжүүлдэг ч дараачийн төсөл, хөтөлбөрийг хөөцөлдөх цаг боломж гаргахад хүндрэлтэй. Санхүүжилт хайх нь эвслийн ажлын тэргүүлэх чиглэлийн нэг хэдий ч үндсэн кампанит ажлаас хөндийрүүлэх нь олонтаа байдаг. Гишүүд эвслийн ажилд хувь нэмрээ оруулах хүсэл зориг дүүрэн хэрнээ тэр үүргээ гүйцэтгэж чаддаггүй ба тавьсан зорилгодоо хүрэх чадавхи дутагддаг. |
| <i>5.Эвсэл одоогийн түвшинд ажиллах нь зүйтэй. (Гэхдээ газар газрын эвслүүд ийм байж бараг чадахгүй, тэр тусмаа бүх шаардлагуудыг зэрэг хангаж чаддаггүй)</i> | Гишүүдийн хоорондын харилцаа маш сайн учраас тэд тавьсан зорилтдоо хүрэх ажлыг өөрсдөө зохион байгуулж үр ашигтай хамтран ажиллах бүлгүүдийг бий болгодог. Гишүүддээ шинэ ололт амжилт, боломжуудын талаар мэдээлэл өгөх, бас хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэхийн тулд урьдын адил зохицуулалт шаардлагатай боловч энэ нь хатуу биш, албадлагагүй байдаг. | Эвсэл үр ашигтай ажилладаг учраас ирээдүйнхээ талаар бодож төлөвлөж чаддаг. Санхүүжилт олохыг сайтар бодож боловсруулж хийдэг ба санхүүжилт олгодог талуудтай үр дүнтэй хамтран ажилладаг. Хүлээсэн үүргээ урам зоригтой биелүүлдэг гишүүддээ итгэл хүлээлгэдэг. |

В. Стратегийн ба дасан зохицох чадавхи

Удирдлага ба зохицуулах байгууллага нь эвслийн гадаад, дотоод өөрчлөлтүүдийг тандаж, үнэлж дүгнэдэг ба шаардлагатай арга хэмжээг авдаг. Гадаад нөхцөл байдалд дасан зохицох ажлыг зохион байгуулдаг.

| <i>Түвшин</i> | В-i. Эвслийн гадаад нөхцөл байдлыг тандах | В-ii. Гишүүдийг дэмжих |
|---------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <i>1.Өөрчлөлт хийх тэргүүлэх чиглэлүүдийг эрэмбэлэх</i> | Гадаад нөхцөл байдлыг эвслийн стратегийг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэл ба боломж талаас нь харж чаддаг боловч гишүүд хоорондоо мэдээллийг системтэй солилцдоггүй, бас олж авсан мэдээллээ эвслийн стратегийг боловсруулж сайжруулахад ашигладаггүй. | Гишүүдийн тухай, юуны өмнө тэдний байнгын үйл ажиллагаа, ажлын үндсэн чиглэл, чадавхи, хоорондын харилцаа, өөц бололцооны талаар системтэй мэдээллийг бараг цуглуулдаггүй, эсвэл маш бага цуглуулдаг. Шинэ гишүүдийг элсүүлэх бодлого байхгүй учраас |

| | | |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| | | эвслийг өргөжүүлэх явц ямар нэгэн зохицуулалтгүй, өрөөсгөл явагдаж зарим байгууллагуудыг түлхдэг. |
| <i>2.Эвсэл одоогийн түвшинд үйл ажиллагаа явуулах нь зүйтэй, гэхдээ цаашдаа өөрчлөлт хийх талаар бодож төлөвлөх нь зүйтэй</i> | Гишүүд гадна орчныг тандах талаар зөвшилцдөг. Үүнд, бодлогын асуудлууд, сонирхогч талуудын үйлдэл, үйл явдлын үр дагавар гэх мэт. Мөн олж авсан мэдээллээ гишүүдэд болон удирдах хороонд үе үе тайлагнадаг. | Наад захын мэдээлэл (гишүүдийн шинэ жагсаалт) бүх гишүүдэд болон олон улсын нарийн бичгийн дарга нарын газарт ил тод байдаг. Шинэ гишүүдийг хаанаас олохоо эвсэл мэддэг, тэднийг өөртөө татахыг оролддог, гэхдээ энэ нь тийм ч алсын хараатай биш, ихээхэн өрөөсгөл бөгөөд цөөхөн хүмүүст зориулагдсан мэт харагддаг. |
| <i>3.Эвслийн үйл ажиллагаа маш тодорхой болж цэгцэрсэн. Гэхдээ зарим талаар сайжруулах юм бий.</i> | Зохицуулагч нь гишүүдээсээ стратегийн чухал асуудлуудаар мэдээлэл аваад дүн шинжилгээ хийх, арга хэмжээ авахыг зохион байгуулдаг. Удирдах хороо хүлээж авсан мэдээллээ ашиглаж эвслийн удирдлагын асуудлаар шийдвэр гаргах, мөн мэдээлэл сурталчилгаа, кампанит ажил явуулах талаар шийдвэр гаргадаг. | Гишүүдээс тэдний одоогийн үйл ажиллагаа болон дундын мэдээллээ хэрхэн хадгалах талаар тогтмол асууж, түүнийг бүх гишүүдэд нээлттэй байлгадаг. Удирдах хороо гишүүнчлэлийг зохистой бөгөөд үр дүнтэй байлгах зарчмыг баримталж шинэ гишүүдийг элсүүлэх шийдвэр гаргадаг. |
| <i>4.Эвсэл одоогийн түвшинд ажиллах нь зүйтэй. Маш тодорхой үйл ажиллагаатай, цэгцэрсэн байгуулага гэдгээ харуулж байна.</i> | Удирдах хороо гадаад нөхцөл байдлын тандах чиглэлийг тодорхойлдог. Харин зохицуулагч нь өөрийн гишүүдэд тус тусын үүргийг нь хуваарилж, шаардлагатай гэвэл тодорхой асуудлаар судлаачдыг гэрээгээр ажилуулдаг. Эвслийн гишүүд байнга мэдээлэл солилцож түүнийгээ хэлэлцдэг. | Гишүүдийн үйл ажиллагаа ба ашиг сонирхлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл байдаг боловч шүүрхай шинэчилдэггүй. Гишүүнчлэлийн тодорхой шалгуур байдгаас гадна шаардлагатай үед алсыг харж шинэ гишүүдийг элсүүлэхэд анхаардаг. |
